

МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2021 оны __ сарын __ өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, Жолоочийн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 213 дугаар тогтоолоор баталсан “Жолоочийн даатгалын сангийн данс байршуулах, санхүүжилтийг төвлөрүүлэх, сангийн хөрөнгийг шилжүүлэх, зарцуулах журам”-д доор дурдсан агуулга бүхий заалт нэмсүгэй:

1/ 4.5. нөхөн төлбөрийг санд буцаан төлөх үүрэгтэй этгээд нь хөдөлмөр эрхэлдэггүй бол Холбоо нь тус этгээдээс батлан даагч шаардаж болно.

2/ 4.6. даатгалын тохиолдлын буруутай этгээдээс шалтгаалсан холбогдох баримт бичиг бүрдүүлэх үйл ажиллагаанаас үл хамааран хохирогчид хуульд заасан хугацаанд нөхөн төлбөрийг олгоно.

3/ 4.12. Хуулийн 18.1.3-т заасны дагуу нөхөн төлбөр олгосон тохиолдолд даатгалын тохиолдлын хохирогчид олгосон нөхөн төлбөрийн дүнгээр сангийн хөрөнгийн дүнг бууруулна.

4/ 4.13. Сангаас олгосон нөхөн төлбөрийг зардлаар бүртгэх бөгөөд Хуулийн 20.2-т заасны дагуу нөхөн төлбөрийг буруутай этгээдээс буцаан нэхэмжлэх эрх үүссэн тохиолдолд авлагаар бүртгэнэ.

5/ 4.14. Тээврийн хэрэгслийн өмчлөгч нь хүчин төгөлдөр Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын гэрээтэй боловч тус даатгалын гэрээнд заасан жолоочийн тоонд багтаагүй буюу нэр дурьдаагүй жолооч уг тээврийн хэрэгслийг жолоодож байх үедээ даатгалын тохиолдол гаргасан бол Хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1-т заасан үндэслэл бий болсон гэж үзнэ.

2.Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 213 дугаар тогтоолоор баталсан “Жолоочийн даатгалын сангийн данс байршуулах, санхүүжилтийг төвлөрүүлэх, сангийн хөрөнгийг шилжүүлэх, зарцуулах журам”-ын 4.4 дэх хэсгийн “Хуулийн” гэсний дараа “22 дугаар зүйлийн”, “22.1,” гэсний дараа “23 дугаар зүйлийн” гэж тус тус нэмсүгэй.

3.Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 213 дугаар тогтоолоор баталсан “Жолоочийн даатгалын сангийн данс байршуулах, санхүүжилтийг төвлөрүүлэх, сангийн

хөрөнгийг шилжүүлэх, зарцуулах журам”-ын дараах хэсэг, заалтыг доор дурдсан агуулгаар өөрчлөн найруулсугай.

1/ Журмын 3.1 дэх хэсэг:

3.1. Албан журмын даатгагчдын холбоо /цаашид “Холбоо” гэх/ нь сангийн данс байршуулах, орлого төвлөрүүлэх, төлбөр тооцоог гүйцэтгэх 3-аас доошгүй харилцагч банкийг сонгож хамтран ажиллана.

2/ Журмын 3.5 дах хэсэг:

3.5.Холбоо нь шалгаруулалтад тэнцээгүй харилцагч банкинд данс нээхийг, мөн данс нээсний дараа тухайн банк нь шалгуурыг хангахгүй болсон тохиолдолд тус банкны дансыг сунгахыг хориглоно.

3/ Журмын 3.6 дах хэсэг:

3.6.Сангийн хөрөнгийг дараах хэлбэрээр байршуулж болно.

Заалт	Хөрөнгө байршуулах хэлбэр	Хөрөнгө байршуулах дээд хувь	Нэгжид ногдох хөрөнгийн дээд хувь
3.6.1	Банкны харилцах, хадгаламж /Монгол банкнаас банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан, тусгай зөвшөөрөлтэй холбоотой аль нэг албадлагын арга хэмжээнд ороогүй, холбогдох этгээдэд үл хамаарах, Банкны тухай хуулийн 16.1.2-д заасан шаардлагыг хангасан банкинд байршуулсан/	100%	33.4%
3.6.2	Банкны хадгаламжийн сертификат /Монгол банкнаас банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан, тусгай зөвшөөрөлтэй холбоотой аль нэг албадлагын арга хэмжээнд ороогүй, холбогдох этгээдэд үл хамаарах, Банкны тухай хуулийн 16.1.2-д заасан шаардлагыг хангасан банкнаас олгосон Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан үнэт цаас/	20%	5%
3.6.3	Засгийн газраас гаргасан өрийн хэрэгсэл	100%	50%
3.6.4	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас /Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан үнэт цаас/	100%	50%
3.6.5	Компанийн өрийн хэрэгсэл /Үнэт цаасны зах зээлд арилжаалагддаг, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.9-т заасан/	20%	10%

3.6.6	Монголын хөрөнгийн биржийн хувьцаат компанийн хувьцаа – 1 ангилал		10%	5%
3.6.7	Монголын хөрөнгийн биржийн хувьцаат компанийн хувьцаа – 2 ангилал		5%	5%
3.6.8	Хөрөнгө оруулалтын нээлттэй сан	/Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 6.2.1-д заасан/	20%	10%
3.6.9	Хөрөнгө оруулалтын хаалттай сан		20%	10%
3.6.10	Хорооноос зөвшөөрсөн бусад хөрөнгө оруулалт		Зөвшөөрсөн хэмжээгээр	Зөвшөөрсөн хэмжээгээр

4/ Журмын 4.2 дах хэсэг:

4.2.Хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.1-т заасны дагуу Холбоо нөхөн төлбөр олгоходоо дараах баримтуудаар баталгаажуулсан байх ба холбогдох эрх бүхий байгууллагын тодорхойлолт, акт, шийдвэрийг цахимаар хүлээн авах боломжийг бүрдүүлсэн байна.

5/ Журмын 4.2.4 дэх хэсэг:

4.2.4.хохирогчийн өргөдөл; /хохирогч нас барсан тохиолдолд Иргэний хуульд заасан хууль ёсны өвлөгчийн өргөдөл/

6/ Журмын 4.5 дах хэсэг:

4.5.Хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-т зааснаас өөр зориулалтаар сангаас хөрөнгө зарцуулахыг хориглоно. Сангаас гарах зардлыг санхүүжүүлэхтэй холбогдсон анхан шатны баримт нь үнэн зөв, бодит тоон мэдээнд үндэслэгдсэн байна. Санхүүгийн тайланд гарсан аливаа алдааг залруулах бол холбогдох нэмэлт баримт бүрдүүлэн залруулга хийж, зөвшөөрсөн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна.

7/ Журмын 5.1.4 дэх хэсэг:

5.1.4.даатгалын нөхөн төлбөр буюу хохирлын хэмжээг тогтооход шаардлагатай мэдээллийг даатгалын тохиолдлын буруутай этгээд, хохирогчоос шаардаж авах;

4. Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 213 дугаар тогтоолоор баталсан “Жолоочийн даатгалын сангийн данс байршуулах, санхүүжилтийг төвлөрүүлэх, сангийн хөрөнгийг шилжүүлэх, зарцуулах журам”-ын 4.2.9 дэх хэсгийг 4.3, 4.2.10 дах хэсгийг 4.4, 4.3 дах хэсгийг 4.7, 4.4 дэх хэсгийг 4.8, 4.5 дах хэсгийг 4.9, 4.6 дах хэсгийг 4.10, 4.7 хэсгийг 4.11 гэж тус тус дугаарлалтыг өөрчилсүгэй.

5. Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 213 дугаар тогтоолоор баталсан “Жолоочийн даатгалын сангийн данс байршуулах, санхүүжилтийг төвлөрүүлэх, сангийн хөрөнгийг шилжүүлэх, зарцуулах журам”-ын 4.2.8, 4.2.11 дэх заалтыг тус тус хассугай.

6.Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН